



**СОНГОЛОН ХАЙРХАН ХХК-ИЙН
ИХ БУЛАНГИЙН ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

(Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сум)

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017362



Улаанбаатар хот
2022 он



АГУУЛГА

ОРШИЛ IV

БҮЛЭГ 1. ОРДЫН ТАНИЛЦУУЛГА..... 1-1

1.1	КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	1-1
1.2	ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	1-1
1.2.1	Ордын байршил, орчны тойм зураг	1-1
1.3	ҮНДСЭН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	1-1
1.4	АЖИЛЛАХ ГОРИМ, АЖИЛЛАХ ХҮЧ	1-2
1.5	ХҮЧИН ЧАДАЛ.....	1-3
1.6	ДЭД БҮТЭЦ.....	1-4

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 2-1

2.1	2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	2-1
2.2	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-2
2.2.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	2-2
2.2.2	Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	2-4
2.2.3	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	2-5
2.2.4	Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	2-6
2.3	НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	2-7
2.4	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-8
2.5	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-9
2.6	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-9
2.7	ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-10
2.8	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	2-12
2.9	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	2-16
2.10	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-25

ДҮГНЭЛТ А

ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ..... В

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1.	Уулын ажлын механикжуулалт.....	1-2
Хүснэгт 1-2.	Ажиллах хүч.....	1-2
Хүснэгт 1-3.	Уурхайн ажиллах горим.....	1-3
Хүснэгт 1-4.	Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	1-3
Хүснэгт 1-5.	Их Булангийн элс хайрганы ордын геологийн нөөцийн тооцоо.....	1-4
Хүснэгт 2-1.	2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	2-1
Хүснэгт 2-2.	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт.....	2-2
Хүснэгт 2-3.	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт.....	2-4
Хүснэгт 2-4.	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт	2-6
Хүснэгт 2-5.	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт	2-6
Хүснэгт 2-6.	Ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэрэгжилт	2-7
Хүснэгт 2-7.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	2-8
Хүснэгт 2-8.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	2-9
Хүснэгт 2-9.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	2-10
Хүснэгт 2-10.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	2-13
Хүснэгт 2-11.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт	2-16



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хүснэгт 2-12. Хэмжилтийн дүн, 10-р сар.....	2-19
Хүснэгт 2-13. Дээж авсан байршил.....	2-20
Хүснэгт 2-14. Карьерын талбайн орчимд бүртгэгдсэн ургамлын жагсаалт	2-23
Хүснэгт 2-15. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	2-25

Графикийн жагсаалт

График 2-1. Уурхайд хийгдсэн хүхэрлэг хийн агууламж	2-17
График 2-2. Уурхайд хийгдсэн азотын давхар ислийн агууламж	2-18
График 2-3. Уурхайд хийгдсэн нийт тоосны агууламж	2-18
График 2-4. $PM_{2.5}$ тоосонцрын хэмжилт	2-19
График 2-5. PM_{10} тоосонцрын хэмжилт	2-20
График 2-6. Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж, мг/л	2-24
График 2-7. Биологийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж, мг/л	2-25

Зургийн жагсаалт

Зураг 1-1. Их Булангийн элс хайрганы ордын байршил	1-1
Зураг 2-1. Хурдны хязгаарлалтыг тэмдэг тэмдэглэгээ	2-3
Зураг 2-2. Замыг сайжруулж, дагтаршуулсан нь.....	2-3
Зураг 2-3. Замын тоосжилт дарах үсалгаа	2-3
Зураг 2-4. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ	2-4
Зураг 2-5. Шатах тослох материал асгарсан үед хэрэглэх саармагжуулах оцеп	2-5
Зураг 2-6. Асгаралтаас урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх сургалт	2-5
Зураг 2-7. Агч, улиас, бургас тариалах үйл явц	2-8
Зураг 2-8. 79-н тохойд техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал	2-9
Зураг 2-9. Гал унтраах багаж хэрэгсэл.....	2-11
Зураг 2-10. Ажилчд сургалтад хамрагдаж байгаа байдал.....	2-11
Зураг 2-11. Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хуудас	2-12
Зураг 2-12. Эмийн сан	2-12
Зураг 2-13. Хог хаягдал цуглуулах сав	2-14
Зураг 2-14. Хогийн цэг, түүний ойр орчим цэвэрлэгээ хийж буй байдал.....	2-14
Зураг 2-15. Хог хаягдлын бүртгэлийн хуудас.....	2-15
Зураг 2-16. Үйлдвэрийн засварын талбай	2-15
Зураг 2-17. Ил задгай хог хаягдал хаях, бие засахыг хориглосон санамж	2-16
Зураг 2-18. Агаарын чанарын хэмжилт, 09 сар	2-17
Зураг 2-19. Агаарын хэмжил, 10-р сар	2-19
Зураг 2-20. Хөрсний дээжлэлт, карьер орчим	2-21
Зураг 2-21. Хөрсний дээжлэлт, хөрсний овоолго орчим.....	2-21
Зураг 2-22. Хөрсний дээжлэлт, кемп.....	2-21
Зураг 2-23. Хөрсөнд агуулагдах хүнд металлын шинжилгээний дүн.....	2-23
Зураг 2-24. Ургамлын мониторинг хийх явц	2-23
Зураг 2-25. Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хуудас	2-27
Зураг 2-26. Ажилчдад сургалтад хамрагдаж буй байдал	2-27



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ОРШИЛ

Сонголон Хайрхан ХХК нь Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Их булангийн элс хайрганы ордод 2022 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний Баялаг Эко ХХК-иар хийлгэж, БОАЖЯ-аар батлуулсан бөгөөд улмаар 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Тус 2022 оны БОМТ-нд тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэн энэхүү биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын 4.1-т заасны дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу Баялаг Эко ХХК боловсрууллаа.



БҮЛЭГ 1. ОРДЫН ТАНИЛЦУУЛГА


1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр	Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их булангийн элс хайрганы орд
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага	<ul style="list-style-type: none"> Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Сонголон Хайрхан ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011179051 Регистрийн дугаар: 5276764 Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг Утас: +976 98009669 +976 99220394 Цахим шуудан: songolon_h@yahoo.com

1.2 ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.2.1 Ордын байршил, орчны тойм зураг

Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын талбай нь Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлана. Ордын талбайн хэмжээ 100.53 га бөгөөд байршлыг Зураг 1-1-т тусгав.



Зураг 1-1. Их Булангийн элс хайрганы ордын байршил

1.3 ҮНДСЭН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Их булангийн элс-хайрганы ордын ашиглалтын гүн их биш, уул-геологийн нөхцөл энгийн тул тээвэртэй ашиглалтын системээр, ил аргаар ашиглана. Усны түвшнөөс дээш элс-хайрга олборлолтыг “экскаватор-автосамосвал”-ын хослолоор явуулна. Усны түвшнөөс доош олборлолтод экскаватор-автосамосвал”-ын хослол дээр нэмэлтээр элс-хайрга сорогч машинаар



(дреджер) олборлолт явуулна. Мөн төсөлд ил уурхайгаас олборлосон элс-хайргыг шигшиж 10 мм ээс дээш ширхэглэхтэй хайргыг бутлахаар тусгасан ба шигшүүр, бутлуур болон туузан конвейер ашиглахар төлөвлөсөн байна. Уулын ажлын механикжуулалтыг Хүснэгт 1-1-д тусгав.

Хүснэгт 1-1. Уулын ажлын механикжуулалт

№	Үндсэн тоног төхөөрөмж	Ажиллах объект	Тоо	Хүчин чадал		Ашиглалтад орсон он
				Нэгж	Хэмжээ	
1.	Экскаватор /Hyundai 290LC, 1.3 м/	Элс-хайрга олборлолт	1	м ³	1.3	2014
2.	Дреджер /YLJSD250, 200 м ³ /	Элс-хайрга олборлолт	1	м ³ /цаг	200	
3.	Ачигч /ZL-50/	Тээврийн хэрэгсэлд ачих, шигшүүрийн бункер тэжээх	1	тн	25	2014
4.	Автосамосвал /Hyundai HD-270, 25тн/	Элс-хайрга тээвэр	2	м ³	3	2014
5.	Бульдозер /Shantui SD-23/	Хөрс хуулга, овоолго	1	м ³	6	2014
6.	Доргиурт шигшүүр /ЗУК-1245/	Элс-хайрга шигших	1	тн/ц	15-80	
7.	Хацарт бутлуур /PE 150x250/	Элс-хайрга бутлах	1	тн/ц	70-150	
8.	Туузан конвейер	Нунтаг материалыг зөөвөрлөх	1	тн/ц	30-60	

Экскаватор нь элс-хайрга олборлолтод ажиллахаас гадна уурхайн ашиглалтын эхний жилийн хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж элс-хайрганы нөөцийг нээж олборлолтод бэлдэнэ. Ашиглалтын 2 дахь жилээс уурхайн хучаас хөрсний зузаан 0.5-1 м, хөрс хуулалтын хэмжээ харьцангуй бага тул бульдозероор уурхайн ашиглалтын талбайн нэг тийш түрж хуулан, буцаан олборлосон орон зайг дүүргэх боломжтой.

1.4 АЖИЛЛАХ ГОРИМ, АЖИЛЛАХ ХҮЧ

Уурхай нь улирлын чанартайгаар 5-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл хоногт 10 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр ажиллана. Төслийн талбайд нийт 25 хүн ажиллах ба уурхайн ажиллах хүчийг Хүснэгт 1-2-д тусгав.

Хүснэгт 1-2. Ажиллах хүч

№	Албан тушаал	Орон тоо	Ажиллах хэсэг
1.	Уурхайн дарга	1	Инженер техникийн ажилчид
2.	Уурхайн мастер	1	
3.	Экскаваторын оператор	1	
4.	Автосамосвалын жолооч	2	Уулын хэсэг
5.	Бульдозерын оператор	2	
6.	Утгуурт ачигчийн оператор	1	
7.	Дреджерийн оператор	1	
8.	Тех ажилчид	4	
9.	Засварчин	1	Үйлдвэрийн хэсэг
10.	Цахилгаанчин	1	
11.	Гагнуурчин	1	
12.	Нягтлан бодогч	1	
13.	Нярав	1	Захиргаа аж ахуйн хэсэг
14.	Жолооч үйлчилгээний	1	
15.	Ах тогооч	1	
16.	Тогооч	1	



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Албан тушаал	Орон тоо	Ажиллах хэсэг
17.	Үйлчилгээний туслах ажилчин	2	
18.	Хамгаалагч	1	
19.	Сахиул	1	
	Нийт	25	4 хэсэг

Дээрх хүснэгтээс харахад инженер техникийн ажилчид 2 хүн, уулын хэсгийн ажилчид 7 хүн, үйлдвэрийн хэсэгт 7 хүн ажиллах ба захиргаа аж ахуйн хэсэгт 9 хүн ажиллаж нийт 25 хүний ажиллах хүчтэй байна.

Уурхайн ажиллах горимыг тооцоолохдоо бүх нийтийн амралтын өдрүүд болон цаг агаарын гэнэтийн тааламжгүй нөхцөлийн үед ажил саатах хоногийг хасаж тооцоолсон ба тоног төхөөрөмжийн урсгал болон үндсэн засварын хугацааг тоног төхөөрөмжийн төрөл зүйл, хүчин чадлаас хамааруулан тооцоонд хасаж өгсөн байна. Төсөлд уурхайн жилд ажиллах хоногийг дараах байдлаар тогтоосон байна. Уурхайн ажиллах горимыг Хүснэгт 1-3-д тусгав.

Хүснэгт 1-3. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Нэгж	Тоо, хэмжээ
1.	Жилд ажиллах боломжит хоног	хоног	149
2.	Цаг агаарын хүндрэл	хоног	3
3.	Амралт, баяр ёслол	хоног	5
4.	Хоногт, ажиллах ээлжийн тоо	хоног	1
5.	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
6.	Ажиллагсдын тоо	хүн	25
7.	Уурхайн ажиллах хоног	хоног	149-3-6=140

Дээрх хүснэгтээс харахад улсын чанартай амралт, баяр ёслолын өдрүүд 5 хоног байна. Цаг агаарын хүндрэлийг тооцоолсон өдрүүд 3 хоног байна. Хоногийн нэг ээлжид ажиллах хүний тоо 1 бөгөөд нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байх ба уурхайн жилд ажиллах өдрүүд 140 хоног байна.

1.5 ХҮЧИН ЧАДАЛ

Уг элс хайрганы орд нь жилд 30 мян.м³ элс хайрга олборлох хүчин чадалтай. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг Хүснэгт 1-4-д тусгав. Төслийн ТЭЗҮ-д уурхайн ашиглалтын жилийг тооцоолохдоо уулын ажлын 30 жил хүртэл 5 жилээр, 6 үе шатаар төлөөлүүлэн ажлын календарьчилсан төлөвлөгөөг боловсруулсан байна.

Хүснэгт 1-4. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд						Нийт
			1-5	6-10	11-15	16-20	21-25	26-30	
1.	Элс-хайрга	мян.м ³	162.08	150.43	172.07	149.73	162.46	147.78	944.54
2.	Хөрс	мян.м ³	70.57	32.81	50.99	63.13	44.83	135.81	398.14
3.	Уулын цул	мян.м ³	232.65	183.24	223.06	212.85	207.29	283.6	1342.68
4.	Овоолго /Кс= 1.33/	мян.м ³	93.86	43.63	67.81	83.96	59.62	180.63	529.52

Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөнд тусгаснаар уурхайн ашиглалтын 30 жилийн хугацаанд уурхайн үйлдвэрлэлийн нөөц 944.5 мян.м³ элс-хайрга байна. Хөрс хуулалтын хэмжээ 398.14 мян.м³ үүнээс сийрэгжилт тооцсоноор овоолгод 529.52 мян.м³ хөрс байршуулна

Ашиглалтын нөөц. Ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог Хүснэгт 1-5-д тусгав.



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хүснэгт 1-5. Их Булангийн элс хайрганы ордын геологийн нөөцийн тооцоо

№	Нөөцийн блок	Элс хайрганы нөөц, м ³		
		Элс хайрганы нөөц, м ³	Үүнээс:	
			Элс	Хайрга
1.	В-I	1,634,273	1,358,081 /83.1%/	276,192 /16.9%/
	а. Усны төвшнөөс дээш	372,316	309,395	62,921
	б. Усны төвшнөөс доош	1,261,957	1,048,686	213,271
2.	В-II	1,917,235	1,560,629 /81.4%/	356,606 /18.6%/
	а. Усны төвшнөөс дээш	256,241	208,580	47,661
	б. Усны төвшнөөс доош	1,660,994	1,352,049	308,945
Нийт		3,551,508	2,918,710	632,798
	а. Усны төвшнөөс дээш	628,557	517,975	110,582
	б. Усны төвшнөөс доош	2,922,951	2,400,735	522,216

Уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог ордын нийт нөөцийн хэмжээнд авч үзвэл нийт 3325.44 мян.м³ элс-хайрганы нөөцтэй байна.

1.6 ДЭД БҮТЭЦ

Усан хангамж: Ажилчид уурхайн талбайд байрлахгүй бөгөөд зөвхөн ажлын цагаар олборлолт явуулна. Ажилчид Сонголон Хайрхан ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрийн харьяанд байрлах ажилчдын байранд байрлана.

Уурхайн ахуйн ус хангамжийг Дархан-Ус суваг ХК-тай байгуулсан цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээгээр зохицуулна.

Цахилгаан хангамж: ДСЦТС ХК-ийн 35/6 кВ элсэн карьер дэд станцаас тмз-1600/35/0,4 төрлийн бууруулах трансформатор ашиглан эрчим хүч татах ажил хийгдэж байна.



БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулсан.

Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны БОМТ-г авч хэрэгжүүлэхэд 21,259,000.00 төгрөг зарцуулахаар төлөвлөж 2022.09.13 өдөр төрийн сангийн 100900013406 тоот дансанд 6,479,500 төгрөгийг төлсөн. 2022 оны БОМТ-ний зардлын хураангуйг Хүснэгт 2-1-д тусгав.

Хүснэгт 2-1. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)	
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,350,000.0	
2.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	2,800,000.0
3.		Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	8,300,000.0
4.		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,000,000.0
5.		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	365,000.0
6.		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000.0
7.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,444,000.0
Нийт зардал		21,259,000.0	



2.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд тусгаснаар Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагаанаас агаарын чанарт дараах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Хөрс хуулж, элс хайрга олборлох, ангилан бутлах, ачиж тээвэрлэх зэрэг процессоос тоосжилт үүсэх
- Овоолго хийх, уурхайн тээврийн замаас тоосжилт үүсэх

Эдгээр агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаар 2022 оны БОМТ-д дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-2-д тусгав. Үүнд:

- Дотоод тээвэрлэлтийн зам дагуу хурдны хязгаар тогтоож 30 км/цагаас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах
- Уурхайн талбай дах дотоод замын сүлжээг сайжруулж, шороон замыг дагтаршуулах
- Олборлолт, шигших, бутлах, тээвэрлэх үйл ажиллагаа явагдах үед усалгаа хийх
- Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг оношилгоонд оруулах

Хүснэгт 2-2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Дотоод тээвэрлэлтийн зам дагуу хурдны хязгаар тогтоож 30 км/цагаас хэтрэхгүй байх хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	0.5-1.0 км зайд уурхайн дотоод тээвэрлэлт хийгдэх ба тээвэрлэлтийн замд 2022 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу 5 болон 20 км/цаг хурдтай явах 2 ш тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан.	100%
2.	Уурхайн талбай дах дотоод замын сүлжээг сайжруулж, шороон замыг дагтаршуулах	Уурхайн нь жилд 140 хоног ажиллах ба ажиллаж байх хугацаандаа 2 сар тутамд уурхайн дотоод замын сүлжээг сайжруулан ажилласан байна.	100%
3.	Олборлолт, шигших, бутлах, тээвэрлэх үйл ажиллагаа явагдах үед усалгаа хийх	Уурхайн тээвэрлэлтийн 1.2 км замын тоосжилт дарах усалгааг 5-9 сард 10 удаа хийж тоос, шороог дарж, орчны агаарт үзүүлэх нөлөөллийг бууруулж ажилласан бөгөөд нэг удаагийн усалгаанд 20 тн ус ашигласан. Усыг бетон зуурмагийн үйлдвэрийн уснаас хангах бөгөөд 2022 онд усны төлбөрт нийт 1,897,000 төгрөг төлсөн.	100%
4.	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг оношилгоонд оруулах	Сонголон Хайрхан ХХК нь Бутлуурын үйлдвэрт чулуу болон элсийг 2022.03.10 өдрийн №22/04 тоот тээврийн гэрээний дагуу тээвэрлэгчийн тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийг хийлгүүлдэг. Уурхайд экскаватор болон ковшийг хэрэглэх бөгөөд тэдгээрийн үзлэг оношилгоог аймгийн техникийн хяналтын үзлэг оношилгоонд 2022 онд хамруулж, хэвийн ажиллагааг хангаж ажилласан.	

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны холбогдох зургуудыг доор тусгалаа.



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-1. Хурдны хязгаарлалтыг тэмдэг тэмдэглэгээ



Зураг 2-2. Замыг сайжруулж, дагтаршуулсан нь



Зураг 2-3. Замын тоосжилт дарах усалгаа



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-4. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ

2.2.2 Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд тусгаснаар Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, газрын гадаргад дараах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Олборлолтын улмаас нийт 70.4 мян.м³ хөрс зайлуулагдах
- Ил уурхайн карьерын талбай буюу 14 га талбайн газрын гадарга үндсэн хэв шинжээ алдах
- Хөрсний овоолгыг 4.5 га талбайд үүсгэх бөгөөд тухайн талбайн газрын гадарга үндсэн хэв шинжээ алдах
- Ахуйн хатуу болон шингэн хог хаягдал, шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрсөн бүрхэвч бохирдох

Эдгээр хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулахаар 2022 оны БОМТ-д дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-3-д тусгав. Үүнд:

- Шатах тослох материалын асгаралт болсон тохиолдолд саармагжуулах хэрэгслийг бэлэн байлгах, асгаралттай тэмцэж буйг хянах
- Асгаралтаас урьдчилан сэргийлэх дотоод журам боловсруулж, асгаралтын иж бүрдлийг хэрхэн ашиглах талаар сургалтыг явуулах
- Нийтийн бие засах газрыг эко, био аргаар болон орчин үеийн шийдлээр хөрсөнд нөлөөлөлгүй байдлаар шийдэх

Хүснэгт 2-3. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Шатах тослох материалын асгаралт болсон тохиолдолд саармагжуулах хэрэгслийг бэлэн байлгах, асгаралттай тэмцэж буйг хянах	Уурхайд шатах тослох материал асгарсан үед оцеп хэрэглэн саармагжуулах бөгөөд асгаралт болсон үеийг тэмдэглэдэг.	100%
2.	Асгаралтаас урьдчилан сэргийлэх дотоод журам боловсруулж, асгаралтын иж бүрдлийг хэрхэн ашиглах талаар сургалтыг явуулах	Болзошгүй байдлаар шатах тослох материал алдагдсан тохиолдолд саармагжуулах хэрэгслийг уурхайд байрлуулсан бөгөөд Сонголон Хайрхан ХХК нь 2022.04.10-ний өдрийн № 12 тоот компанийн дотоод тушаалаар “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс”-ыг байгуулж, асгаралтаас сэргийлэх дотоод журмыг боловсруулан, түүнийг дагаж мөрдөн ажиллаж байна. /Тайланд хавсаргаав/	100%
3.	Нийтийн бие засах газрыг эко, био аргаар болон орчин үеийн	Сонголон Хайрхан ХХК нь Мөнхийн хүндлэл ХХК болон ЧБББА ХХК-ийн эко	30%



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
шийдлээр нөлөөлөлгүй байдлаар шийдэх	хөрсөнд	жорлон, био нойлыг судлан үнийн санал авсан бөгөөд эдгээр эко жорлонгоос өөрийн хэрэгцээнд тохируулан суурилуулахаар төлөвлөж байна.	

Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны холбогдох зургуудыг доор тусгалаа.



Зураг 2-5. Шатах тослох материал асгарсан үед хэрэглэх саармагжуулах оцөн



Зураг 2-6. Асгаралтаас урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх сургалт

2.2.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд тусгаснаар Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагаанаас усан орчинд дараах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Ажилчдын унд ахуй, зам талбайн усалгаа, биологийн нөхөн сэргээлтэд усыг зохисгүй ашигласнаар усны нөөцөд хохирол учруулах
- Ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зүй зохистой зайлуулахгүй тохиолдолд гадаргын усыг бохирдуулах



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Эдгээр усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулахаар 2022 оны БОМТ-д дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-4-д тусгав. Үүнд:

- Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаях
- Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах

Хүснэгт 2-4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаяж байх, хянаж байх	Сонголон хайрхан ХХК нь Дархан хотын тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ-тай 2022.09.01-ний өдөр 26 тоот хамтран ажиллах гэрээгээр байгуулсан бөгөөд 2022.09.20 өдөр 18 м ³ хогийг ачуулсан байна.	100%
2.	Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах	Уурхайд ажилчид байрлахгүй бөгөөд ахуйн усыг Дархан-Ус суваг ХК-тай цэвэр ус хангах, бохир усыг татуулах 2017.04.24-ний өдрийн 767 тоот гэрээний дагуу үйлдвэрээс авч ажиллаж байна.	100%

Дархан хотын ТҮГ-тай байгуулсан Хог хаягдал тээвэрлэх болон Дархан-Ус суваг ХК-тай байгуулсан Цэвэр усаар хангах, бохир усыг татуулах гэрээг тайланд хавсаргав.

2.2.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагаанаас 10.9 га талбай шүүд эвдрэл орох ба үржил шимт хөрс хуулах ажил хийгдэж ургамлан нөмрөг устгах сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна гэж тусгасан байна.

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаар уурхайн ашиглалтын дараагаар биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-5-д тусгав.

Хүснэгт 2-5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Уурхайн ашиглалтын дараагаар биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийх	Сонголон Хайрхан ХХК нь биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд уурхайн ашиглалтын жилүүдэд мод тарих ажлыг хийхээр төлөвлөсөн. Үүний дагуу 2022 онд лицензийн талбайн зүүн хойд талд 220 ш модыг тарьж, арчилгаа торолгоог хийж байна. /Ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэсэгт дэлгэрэнгүй тусгав/	100%

Мөн БОМТ-нд тусгасан ногоон байгууламжийн тохижилтын ажлаас гадна уурхайн тээвэрлэлтийн замд 5 болон 20 км/цаг хурдтай явах 2 ш тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан, уурхайн дотоод замын сүлжээг сайжруулсан, уурхайн тээвэрлэлтийн 1.2 км замын тоосжилт дарах усалгааг 5-9 сард 10 удаа хийж тоос, шороог дарж, орчны агаарт үзүүлэх нөлөөллийг бууруулж ажилласан, болзошгүй байдлаар шатах тослох материал алдагдсан тохиолдолд саармагжуулах хэрэгслийг уурхайд байрлуулж үйл ажиллагааг тогтмол хянаж, орчны ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг хянаж, бууруулж төлөвлөгөөг 100% биелүүлэн ажилласан.



2.3 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны БОМТ-нд Их Булангийн элс хайрганы ордын ногоон байгууламжийн төлөвлөгөөний хүрээнд уурхайн талбайн 10 % буюу 10.05 га талбайд мод тарих ажлыг төлөвлөсөн байна.

Сонголон Хайрхан ХХК нь уурхайн лицензийн талбайн зүүн хойд талд мод тарих ажлын хүрээнд нийт 220 ш агч, улиас, бургасыг тарьж, ургуулан арчилгаа тордолгоог 100%-ийн биелэлттэй хэрэгжүүлж байна.

Ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-б-д тусгав.

Хүснэгт 2-б. Ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Төслийн талбайн 10%-д ноогдох талбайд ногоон байгууламж байгуулж, мод тарих	2022 оны БОМТ-нд тусгасны дагуу лицензийн талбайн зүүн хойд талд бургас, агч, улиас зэрэг нийт 220 ш мод тарьсан.	100%

Мод тарих ажлын хүрээнд 220 ш модны суулгацыг 455,000 төгрөгөөр худалдан авч, экскаватор (525,000₮), авто ачигч (560,000₮), усны машин (490,000₮) зэрэг техникүүдийг ажиллуулж, 10 хүнийг 2 өдөр ажиллуулсан бөгөөд цалин 1,500,000₮ олгож нийт 3,530,000 ₮ зарцуулсан.

Ногоон байгууламжийн төлөвлөгөөний биелэлтийг доорх зурагт тусгав.





Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-7. Агч, улиас, бургас тариалах үйл явц

2.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны БОМТ-нд Их Булангийн элс хайрганы ордын биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж Орхон сумын Баян-Өлзийт багийн 79-н тохой дахь Хайрганы карьер явуулж байсан 2.2 га эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг төлөвлөсөн байна.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-7-д тусгав.

Хүснэгт 2-7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны БОМТ-нд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Сонголон Хайрхан ХХК нь орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж Орхон сумын Баян-Өлзийт багийн 79-н тохой дахь Хайрганы карьер явуулж байсан 2.2 га эвдэрсэн газрыг нөхөн сэргээхээр төлөвлөсөн байна.	Сонголон Хайрхан ХХК нь 2022 онд 79-н тохой дахь хайрганы карьер явуулж байсан 2.2 газарт техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн байна. 2022.10.20-2022.10.24-ийг хүртэл нийт 4 өдөр ажилласан ба 6,321,000.00 төгрөг зарцуулжээ.	100%

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд гүйцэтгэсэн ажлыг доорх зурагт тусгав.



Зураг 2-8. 79-н тохойд техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал

2.5 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Их Булангийн элс хайрганы ордын талбай орчимд эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг төлөвлөөгүй болно.

2.6 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны БОМТ-нд Их Булангийн элс хайрганы ордын түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Археологи Палеонтологийн судалгааг хийлгэх ажлыг төлөвлөсөн байна.

Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-8-д тусгав.

Хүснэгт 2-8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний хүрээнд Археологи Палеонтологийн судалгааг хийлгэх	<ul style="list-style-type: none"> Сонголон Хайрхан ХХК нь Улаанбаатар их сургуулийн Түүх, археологийн тэнхимээр 2021 онд Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын тайланг боловсруулсан байна. 	100%



- ШУА-ийн Палентологийн хүрээлэнгээр Палентологи судалгааны ажил хийлгүүлсэн бөгөөд 2021.10.11-ний өдрийн № Т/83 тоот дүгнэлтэй.

Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын дүгнэлт болон Палеонтологийн хайгуул, судалгааны ажлын дүгнэлтийг тайланд хавсаргав.

2.7 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны БОМТ-нд Их Булангийн элс хайрганы эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон аюул ослоос урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, арилгах талаарх хууль, дүрэм, журмын дагуу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллах, гэнэтийн ослын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, ХАБЭА-н арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах ажлуудыг төлөвлөсөн байна. Үүнд:

- Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах. Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллагсдад сургалт зохион байгуулах
- ХАБЭА сургалт зохион байгуулах
- Ажилчдыг эрүүл мэндийн шинжилгээ оношилгоонд хамруулж, ажлын байранд эмийн санг бэлтгэх

2022 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-9-д тусгав.

Хүснэгт 2-9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах	Уурхайд гал унтраах багаж, хэрэгслийг кемпийн баруун урд талд байрлуулсан.	100%
2.	ХАБЭА сургалт зохион байгуулах	Уурхайд нийт 25 хүн ажиллах бөгөөд ХАБЭА сургалтыг шинээр ажилтан авах бүрт, мөн жил бүр ХАБЭА давтан сургалтыг зохион байгуулдаг. Үүний дагуу 2022 онд компанийн нийт 20 ажилчдыг ХАБЭА сургалтад хамруулсан байна.	100%
3.	Ажилчдыг эрүүл мэндийн шинжилгээ оношилгоонд хамруулж, ажлын байранд эмийн санг бэлтгэх	2022 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу ажилчдыг Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Поликлиник-тэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 2022.11.01-ний 01 тоот гэрээ байгуулсны дагуу ажилчдыг үзлэгт хамруулан ажиллаж байна. Уурхайн кемпэд анхны тусламжийн эмийн санг байрлуулсан.	100%

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэсэн ажлын холбогдох зургийг доор тусгав.



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-9. Гал унтраах багаж хэрэгсэл



Зураг 2-10. Ажилчд сургалтад хамрагдаж байгаа байдал

Зурагт өгөгдсөн өдөр: 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдөр
340 дугаар тусламжийн 3 дугаар хэсэгт

"ЭРҮҮЛ МЭНДЭЙН УРЬДЧИЛСАН ҮЗЛЭГИЙН ХУУДАС"

А.Ажил ологчийн танилцуул

- Ажил ологчийн нэр: СОНГОЛОН ХАЙРХАН ХХК
- Уулзга хийх зөвлөлийн байгууллагын нэвт байршил: Дархан-Уул аймгийн Найрвандын уруул мажарын 2-р тус.
- Ажилчны өсөг нэр: З.МОНКУУДРАМ
- Төрийн ор. сэд. хэвд: 00.78.0702018.1987-06-12
- Ажилчны нэгж, хэсгийн нэр: СОНГОЛОН ХАЙРХАН ХХК БЗ-ын үйлдвэр
- Ажилтны үргэлжлэх нэр: Байрлал
- Ажилын байрны нэгжид дотуур урвал: Хэвчин, Хэвчин бус АМА

Б.Зөвлөлийн байгууллагын танилцуул

№	Үзлэгийн төрөл	Онц	Уулзга хийсэн өдөрний гарын үсэг
1	Зурх судас	СЭЦЭЭ	[Signature]
2	Дунд	СЭЦЭЭ	[Signature]
3	Мэдэрл	СЭЦЭЭ	[Signature]
4	Хорлоого	СЭЦЭЭ	[Signature]
5	Чөл хөвдөр хоолой	СЭЦЭЭ	[Signature]
6	Няг	СЭЦЭЭ	[Signature]
7	Шал	СЭЦЭЭ	[Signature]
8	Мэс засал	СЭЦЭЭ	[Signature]
9	Сурьца	СЭЦЭЭ	[Signature]
10	БЭДЭР	СЭЦЭЭ	[Signature]
11	Арьс харшил	СЭЦЭЭ	[Signature]
12			
13			
14			
15			

Эрүүл мэндийн нэгдсэн дүгнэлт: (ТЭНЦЭН) ТЭНЦЭХҮЙ.

Эрүүл мэндийн үзлэг хийсэн эмнэлгийн байгууллагын даргын гарын үсэг: [Signature]

Зөвлөлийн байгууллагын Тамга

Зурагт өгөгдсөн өдөр: 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдөр
340 дугаар тусламжийн 3 дугаар хэсэгт

"ЭРҮҮЛ МЭНДЭЙН УРЬДЧИЛСАН ҮЗЛЭГИЙН ХУУДАС"

А.Ажил ологчийн танилцуул

- Ажил ологчийн нэр: СОНГОЛОН ХАЙРХАН ХХК
- Уулзга хийх зөвлөлийн байгууллагын нэвт байршил: Дархан-Уул аймгийн Найрвандын уруул мажарын 2-р тус.
- Ажилчны өсөг нэр: З.МОНКУУДРАМ
- Төрийн ор. сэд. хэвд: 00.78.0702018.1987-06-12
- Ажилчны нэгж, хэсгийн нэр: СОНГОЛОН ХАЙРХАН ХХК
- Ажилтны үргэлжлэх нэр: Байрлал
- Ажилын байрны нэгжид дотуур урвал: Хэвчин, Хэвчин бус АМА

Б.Зөвлөлийн байгууллагын танилцуул

№	Үзлэгийн төрөл	Онц	Уулзга хийсэн өдөрний гарын үсэг
1	Зурх судас	СЭЦЭЭ	[Signature]
2	Дунд	СЭЦЭЭ	[Signature]
3	Мэдэрл	СЭЦЭЭ	[Signature]
4	Хорлоого	СЭЦЭЭ	[Signature]
5	Чөл хөвдөр хоолой	СЭЦЭЭ	[Signature]
6	Няг	СЭЦЭЭ	[Signature]
7	Шал	СЭЦЭЭ	[Signature]
8	Мэс засал	СЭЦЭЭ	[Signature]
9	Сурьца	СЭЦЭЭ	[Signature]
10	БЭДЭР	СЭЦЭЭ	[Signature]
11	Арьс харшил	СЭЦЭЭ	[Signature]
12			
13			
14			
15			

Эрүүл мэндийн нэгдсэн дүгнэлт: (ТЭНЦЭН) ТЭНЦЭХҮЙ.

Эрүүл мэндийн үзлэг хийсэн эмнэлгийн байгууллагын даргын гарын үсэг: [Signature]

Зөвлөлийн байгууллагын Тамга

Зурагт өгөгдсөн өдөр: 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдөр
340 дугаар тусламжийн 3 дугаар хэсэгт

"ЭРҮҮЛ МЭНДЭЙН УРЬДЧИЛСАН ҮЗЛЭГИЙН ХУУДАС"

А.Ажил ологчийн танилцуул

- Ажил ологчийн нэр: СОНГОЛОН ХАЙРХАН ХХК
- Уулзга хийх зөвлөлийн байгууллагын нэвт байршил: Дархан-Уул аймгийн Найрвандын уруул мажарын 2-р тус.
- Ажилчны өсөг нэр: З.МОНКУУДРАМ
- Төрийн ор. сэд. хэвд: 00.78.0702018.1987-06-12
- Ажилчны нэгж, хэсгийн нэр: СОНГОЛОН ХАЙРХАН ХХК БЗ-ын үйлдвэр
- Ажилтны үргэлжлэх нэр: Байрлал
- Ажилын байрны нэгжид дотуур урвал: Хэвчин, Хэвчин бус АМА

Б.Зөвлөлийн байгууллагын танилцуул

№	Үзлэгийн төрөл	Онц	Уулзга хийсэн өдөрний гарын үсэг
1	Зурх судас	СЭЦЭЭ	[Signature]
2	Дунд	СЭЦЭЭ	[Signature]
3	Мэдэрл	СЭЦЭЭ	[Signature]
4	Хорлоого	СЭЦЭЭ	[Signature]
5	Чөл хөвдөр хоолой	СЭЦЭЭ	[Signature]
6	Няг	СЭЦЭЭ	[Signature]
7	Шал	СЭЦЭЭ	[Signature]
8	Мэс засал	СЭЦЭЭ	[Signature]
